



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/361

Булган сум

Хяналт шалгалтын арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, 17.2.20, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2, 23.1.12, Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/21 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын 2024 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар, 2024 онд Салбарын төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 30 объект, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх, иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, замын маршрут, шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх ажилд шаардагдах 16,545,000 (арван зургаан сая таван зуун дөчин таван мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалт хийх төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг удирдамж, төлөвлөгөөнд заасны дагуу чанарын өндөр түвшинд зохион байгуулж, шаардагдах хүн хүч, техник хэрэгслээр тухай бүрд нь хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж хамтран ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр), Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Засаг Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010464



ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Шалгалтын зорилго

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/21 дүгээр тушаалыг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ус ашиглагч иргэн, хуулийн этгээд болон хууль бусаар мод, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, агнуурын нөөц газруудад амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан агнууртай тэмцэх хяналт шалгалтыг Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах цаашид авах арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр

Төлөвлөгөөт хяналт шалгалт:

Төлөвлөгөөт хяналт шалгалтад Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/21 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт”-д нэр орсон 30 объект хамрагдана.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектыг байгаль орчны чиглэлээр дараах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшинг тогтооно. Үүнд:

01.1.4 кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас;

01.2.2 кодтой “Ой ашиглалтын мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах;

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт:

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд хамрагдана.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй эсэх, үнэлгээгээр тавигдсан нөхцөл шаардлагыг биелүүлж ажилласан эсэх;

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй эсэх, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнасан эсэх;

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6-д тус тус заасан ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл авч гэрээ байгуулсан эсэх;

Хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт, зөвшөөрөл авсан эсэх;

Цэвэрлэх байгууламж байгуулж, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж байгаа эсэх;

Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолуур суурилуулж, эхлэлийн акт үйлдүүлсэн эсэх;

2023 оны усны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлсөн эсэх,

Амьтны тухай хуулиар заасан агнуурын амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан, агнууртай тэмцэх;

Ан агнуурын холбоотой үйл ажиллагаанд Амьтны тухай хууль тогтоомжид заасан зөвшөөрөл /эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл, гэрээ г.м/ гарал үүслийн тодорхойлолт болон бусад баримт бичигт хяналт шалгалт хийх;

Амьтны тухай хуулиар заасан хориглосон арга, зэвсэг хэрэгсэл, үйл ажиллагаанд хяналт тавих;

Хууль бусаар мод, ойн дагалт баялаг бэлтгэх, худалдах, худалдан авах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх;

Ойн тухай хуулийн 26 дугаар зүйлийн хэрэгжилт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавих;

Тухайн орон нутагт ойн сан бүхий газрыг гэрээгээр эзэмшиж мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагуудад шалгалт хийх;

Байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, худалдаалах байдалд болон тээврийн хэрэгслийн ачаа тээшинд үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт:

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, дурьдсан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Гурав. Шалгалтын төрөл

Төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус хяналт шалгалт;

Дөрөв. Шалгалтын арга

Хяналт шалгалтыг батлагдсан удирдамжид тусгагдсан асуудлын хүрээнд хийхээс гадна Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

2024 онд Салбарын хяналт шалгалтад хамрагдах 30 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээс гадна, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд, хөдөлгөөнт эргүүл хэлбэрээр хяналт тавих, иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу шалгалт хийх, тээвэрлэгдэж буй ачаа тээшинд үзлэг хийх зэрэг аргуудаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж гүйцэтгэх бөгөөд шалгалттай холбоотой баримт бичгийг хянан үзэх, шаардлагатай тохиолдолд дуу дүрсний бичлэг хийх, фото зураг авах, төрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа баримт бичигтэй тулгалт хийх, тэдгээрийг хуулбарлах, лавлагаа мэдээлэл авах, хариуцлага ногдуулах зэрэг ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ.

Тав. Шалгалтын бүрэлдэхүүн

- 1.Аймгийн Засаг даргын Тамгын газар - 1
- 2.Байгаль орчин, аялал жуулчлалын газар - 3
- 3.Цагдаагийн газар - 1
- 4.Сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал маршрутын дагуу зохион байгуулна.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

Хамтарсан хяналт шалгалтын хүрээнд хийгдсэн шалгалтын танилцуулгыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргад танилцуулж, аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбарын хяналтын газарт тайлагнана. Мөн хяналт шалгалтын талаар цаашид авч хэрэгжүүлэх санал боловсруулж, олон нийтэд мэдээлж ажиллана.

Найм. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

2023 онд төлөвлөгөөт хяналт шалгалт болон иргэн, хуулийн этгээдэд, хууль бусаар мод бэлтгэх, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, агнуурын нөөц газруудад амьтныг агнах, барихыг хориглосон хугацаанд хууль бус ан агнууртай тэмцэх урьдчилан сэргийлэх шалгалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтаар 4 зөрчлийг бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж, байгаль орчны эсрэг зөрчил гаргасан 38 иргэн, хуулийн этгээдэд 19,750,000 төгрөгийн шийтгэл, 31,723,200 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж аймаг, сумын төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

oooOOOooo

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 20 ны/ний өдрийн А/361 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН МАРШРУТ
5 ДУГААР САРД**

д/д	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа	
1	2	3	4	
1	Булган-Бүрэгхангай	80	3	
2	Бүрэгхангай сумын нутгаар	260		
3	Бүрэгхангай-Булган	80		
Дүн		420	3	
Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад зарцуулагдах хөрөнгө				
д/д	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Шатахуун	420/100*17=71,4 л	3 680 төг	263 000
2	Томилолт	5 хүн * 3 хоног =15	90 000 төг	1 350 000
Дүн				1 613 000

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ
БУЙ 171 ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
ЗАМЫН МАРШРУТ 6 ДУГААР САРД**

д/д	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	ААН-ийн тоо	Хугацаа/Хоног
1	2	3	4	5
1	Булган – Бугат	30	12	2
2	Бугат сумын нутгаар	20		
3	Бугат-Сэлэнгэ	90		
4	Сэлэнгэ сумын нутгаар	15	3	1
5	Сэлэнгэ-Хангал	40		
6	Хангал сумын нутгаар	20	11	1
7	Хангал -Хялганат тосгон	25		
8	Хялганат тосгоны нутгаар	15	3	1
9	Хялганат- Булган	110		
10	Булган- Сайхан	110	9	1
11	Сайхан сумын нутгаар	20		
12	Сайхан- Баян-Агт	70	33	2
13	Баян-Агт сумын нутгаар	30		
14	Баян-Агт-Хутаг-Өндөр	180	29	2
15	Хутаг-Өндөр сумын нутгаар	25		
16	Хутаг-Өндөр-Тэшиг	110	7	1
17	Тэшиг сумын нутгаар	20		
18	Тэшиг-Булган	246	17	1
19	Булган-Орхон	22		
20	Орхон сумын нутгаар	30	2	1
21	Орхон-Хишиг-Өндөр	45		
22	Хишиг-Өндөр-Бүрэгхангай	70	3	1
23	Бүрэгхангай –Дашинчилэн	70		
24	Дашинчилэн-Баяннуур	30	4	1
25	Баяннуур сумын нутгаар	10		

26	Баяннуур-Рашаант	75	16	1
27	Рашаант сумын нутгаар	20		
28	Рашаант-Гурванбулаг	75	5	1
29	Гурванбулаг сумын нутгаар	15		
30	Гурванбулаг-Могод	70	15	1
31	Могод сумын нутгаар	15		
32	Могод-Булган	131		
Дүн		1854	171	15
Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад зарцуулагдах хөрөнгө				
д/д	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Шатахуун	1884/100*17= 315,2 л	3 680 төг	1 160 000
2	Томилолт	3 хүн * 15 хоног =45	90 000 төг	4 050 000
				5 210 000

Тайлбар: “Алтаргана-2024” арга хэмжээ зохион байгуулагдах тул манай аймагт зорин ирэх аялагч жуулчдын тоо эрс нэмэгдэхтэй холбоотойгоор аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээний чанар стандартыг сайжруулах, жуулчдын аюулгүй байдал тав тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор энэхүү хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЗАМЫН МАРШРУТ
8 ДУГААР САРД**

д/д	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа	
1	2	3	4	
1	Булган –Орхон	22	1	
2	Орхон сумын нутгаар	50		
3	Орхон - Хишиг-Өндөр	45		
4	Хишиг-Өндөр сумын нутгаар	50	3	
5	Хишиг-Өндөр - Могод	60		
6	Могод сумын нутгаар	100		
7	Могод - Сайхан	130	3	
8	Сайхан сумын нутгаар	100		
9	Сайхан - Баян-Агт	70	2	
10	Баян-Агт сумын нутгаар	100		
11	Баян-Агт - Булган	150		
Дүн		877	9	
Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад зарцуулагдах хөрөнгө				
№	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Шатахуун	877/100*17=150 л	3 680 төг	552 000
2	Томилолт	5 хүн * 9 хоног =45	90 000 төг	4 050 000
				4 602 000

**30 ОБЪЕКТОД ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
ЗАМЫН МАРШРУТ 9 ДҮГЭЭР САРД**

д/д	Хяналт шалгалт явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа
1	2	3	4
1	Булган - Хутаг-Өндөр	150	2
2	Хутаг-Өндөр сумын нутгаар	50	
3	Хутаг-Өндөр – Тэшиг	103	2
4	Тэшиг сумын нутгаар	50	
5	Тэшиг - Булган	246	
6	Булган - Бугат	30	1

7	Бугат сумын нутгаар	50		
10	Бугат – Сэлэнгэ	90	2	
11	Сэлэнгэ сумын нутгаар	50		
12	Сэлэнгэ – Хялганат тосгон	26	2	
13	Хялганат тосгоны нутгаар	30		
14	Хялганат - Хангал	25	1	
15	Хангал - Булган	90		
Дүн		990	10	
Төлөвлөгөөт хяналт шалгалтад зарцуулагдах хөрөнгө				
д/д	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Шатахуун	$1140/100*17=168,3$ л	3 680 төг	620 000
2	Томилолт	5 хүн * 10 хоног =50	90 000 төг	4 500 000
Дүн				5 120 000

НИЙТ ЗАРДАЛ

д/д	Хяналт шалгалт явуулах хугацаа	Нийт өртөг
1	2	3
1	5 дугаар сард	1 613 000
2	6 дугаар сард	5 210 000
3	8 дугаар сард	4 602 000
4	9 дүгээр сард	5 120 000
Нийт дүн		16 545 000